



НИЙСЛЭЛИЙН
НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 01 сарын 22 өдөр

Дугаар А/04

Улаанбаатар хот

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл
ахуйн зөвлөл байгуулах тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг, 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх заалт, 27 дугаар зүйлийн 27.2, 27.3, 27.4 дэх хэсэг, Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114 дүгээр тушаал, Газрын дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн тушаах нь:

1. Байгууллагын ажилтан, албан хаагчдын ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, эрүүл аюулгүй ажлын байрны орчин нөхцөлийг бий болгох, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, санал, зөвлөмж гаргах, холбогдох хууль, тогтоол, дүрэм журмыг мөрдүүлэх үүрэг бүхий Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр хийх ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг цаг тухай бүр тайлагнаж ажиллахыг Зөвлөлийн нарийн бичгийн дарга (Б.Жаргалсайхан)-д даалгасугай.


3. Тушаалын хэрэгжилтэд хяналт, тавьж ажиллахыг Дотоод хяналт, шинжилгээ-үнэлгээ хариуцсан ажилтан (Б.Ууганцэцэг)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Л.ДЭЛГЭР

Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын
даргын 2024 оны 01 дугаар сарын 22-ны
А/04 дугаар тушаалын хавсралт



**ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ,
ЭРҮҮЛ АХУЙН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮНД**

| | |
|------------------|---|
| Зөвлөлийн дарга: | Инженерийн байгууламжийн ашиглалт үйлчилгээний албаны дарга |
| Гишүүд: | Үйлдвэрлэл үйлчилгээний албаны дарга Ерөнхий инженер Хууль, эрх зүй, тогтоол шийдвэрийн хэрэгжилт хариуцсан ажилтан Их эмч Нийтийн хоолны инженер технологич Байр харуцсан менежер (зөвшилцөхөөр) Ажилтан (зөвшилцөхөөр) |
| Нарийн бичиг: | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан |